

БАТЛАВ  
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Ж.ЛХАГВАСҮРЭН

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ГЕОДЕЗИЙН БАЙНГЫН ЦЭГ  
ТЭМДЭГТИЙГ НӨХӨН СЭРГЭЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 05 сарын 01 –ний өдөр

Улаанбаатар хот

№	Ажлын нэр төрөл	Тайлбар
1.	Ажил гүйцэтгэх үндэслэл	- Газрын тухай хууль - Геодези Зураг зүйн тухайн хууль - Геодези Байнгын цэг тэмдэгт байгуулах дүрэм БД /11-104-109/ - “Геодезийн цэг, тэмдэгт байгуулах заавар.” УГЗЗГ
2.	Ажлын зорилго	-Устаж үгүй болсон геодезийн байнгын цэг тэмдэгтүүдийг нөхөн сэргээж статик хэмжилт хийж, хувийн хэрэг хөтөлж, мэдээллийн санд бүртгэх.
3.	Хамрах хүрээ	Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт
4.	Ажлын иж бүрдэл	<b>1. Геодезийн цэг тэмдэгт суулгах газарт тавих үндсэн шаардлага:</b> Төв ба репер нь үндсэн хоёр шаардлага хангасан байх ёстой. Үүнд: - Цэгийн хэлбэр хийц болон түүнийг суулгах гүн, гаднах тэмдэглэл нь урт хугацаанд хадгалагдах нөхцлийг; - Төв ба реперийг эрж олоход хялбар, хэмжилт хийх нөхцөл, аюулгүйн ажиллагаа. Цэгийн удаан хадгалагдах боломжийг хангахын тулд доорх газарт суулгахыг хориглоно. Үүнд: - Уулын хажуу, өмнөд бэл газар; - Өвөл нь цас их шуурч, бөөгнөрдөг газар; - Зундаа чийг их хуримтлуулдаг, өвөл нь цас их унадаг нам газар; - Хөлдөөсний ан цавтай, үер их буудаг газар зэрэг болно. - Хот, суурин газарт барилга, байгууламж, зам талбай барихаар төлөвлөсөн, усан цахилгаан станц, уулын ажил өрнөх, усжуулалт хийгдэх гэх мэт аж ахуйн үйл ажиллагаа явагддаг, нуранги, мөсжилт явагдах, намаг шалбаагтай г.м. байгалийн хүчин зүйлд автагдах газар; - Радио долгион (радио станц, радар, радио долгион дамжуулах антен г.м) дамжуулах эх үүсвэрийн ойролцоо,

		<p>цахилгаан дамжуулах шугамын орчинд;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Газрын тос, шатдаг хий, гүний ус олборлолтын цамхагын дэргэд. г.м.</li> <li>- Инженер геологийн хүнд нөхцөлтэй газарт (хөрсний гулсалт, нуранги, хөрсний усны өндөр түвшинтэй, овоолт, суулт г.м.)</li> </ul> <p>Түүнчлэн геодезийн цэгийн төв ба репер суулгах газар нь хүрч очих, олох, ашиглахад хялбар, удаан хугацаанд хадгалагдах нөхцлийг аль болох бүрдүүлсэн, хэмжилтийг аль ч улиралд, ямар ч тохиолдолд тасралтгүй хийх боломжтой байх.</p>
5.	Гүйцэтгэх ажлын үе шат	<p><b>1. Бэлтгэл ажлын үе шат</b></p> <p><b>Геодезийн цэг, тэмдэгтийн судалгаа хийх</b></p> <p>Геодезийн цэг, тэмдэгтийн судалгааны ажлаар:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Урьд жилүүдэд байгуулсан геодезийн сүлжээний цэгүүдэд үзлэг тооллого хийх, түүний бүрэн бүтэн байдал, ашиглах боломж, засвар үйлчилгээний хэмжээг судалж тогтоох:</li> <li>- Цэгийн төв ба хөрсний репер суулгах газрын хөрсний бүтэцтэй нарийвчлан танилцаж, цэгийн хийц, хэлбэрийг сонгох зэрэг ажил гүйцэтгэнэ.</li> </ul> <p>Судалгаа, сэргээн босголт, цэг суулгалтын үе шатанд цэг, тэмдэгтийн хувийн хэргийг зохих зааврын дагуу бүрдүүлнэ.</p> <p><b>2. Төв ба репер цэгийг бэлтгэх материалыг сонгох</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Геодезийн цэгийн төв ба реперт бэхлэх маркыг ширэм буюу гангаар бэлтгэнэ.</li> <li>- Маркны дээд хэсэгт геодезийн цэгийн төв, реперийн нэрийн товчлол болох ГЦХ гэсэн үсэг ба дугаар, гүйцэтгэгч байгууллагын нэрийн товчлол зэргийг 4 оронтойгоор товойлгож цутгана. Үсэг болон тооны өндөр 5 мм байна.</li> <li>- Цэгийн төв ба репер бэлтгэхэд романцемент, намгархаг, хужир, марзтай газарт силикат цемент ашиглахыг тус тус хориглоно.</li> <li>- Төвлөрсөн журмаар төв ба репер бэлтгэхэд 300-аас доошгүй маркын цемент, эзлэхүүнээрээ 1:2:4 харьцаа бүхий цемент, элс, хайрганы зуурмаг хэрэглэнэ.</li> </ul> <p><b>3. ГЕОДЕЗИЙН БАЙНГЫН ЦЭГ, ТЭМДЭГТИЙГ БЭХЛЭХ</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Цэгийн төв, реперийг суулгахад хөрсний хөлдөлт, гэсэлтийн гүнийг тодорхойлох.</li> <li>- Геодезийн цэгийн төв ба хөрсний реперийг суулгах гүнийг тогтоохдоо “Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг суулгах гүнийг тогтоох бүсчилсэн зураг”-ийг ашиглах.</li> </ul>



6.	Техникийн шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Барилгын норматив баримт бичгийн тогтолцоо. Үндсэн журам. БНБД10-01-99.</li> <li>- "Геодезийн цэг, тэмдэгт байгуулах заавар". УГЗЗГ. 1984 он</li> <li>- 1: 5000, 1:2000, 1:1000, 1:500-ны масштабтай байр зүйн дэвсгэр зургийн томъёолсон тэмдэг. УГЗЗГ. 2002 он</li> <li>- Геодези, зураг зүйн нэр томъёо. ШУТИС. 2000 он.</li> <li>- Геодези, зураг зүйн тухай хуулиас. 1997 он.</li> <li>- I, II, III ба IV ангийн нивелирдлэгийн заавар. УГЗЗГ.1998 он.</li> <li>- 1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ны масштабтай байр зүйн зураглалын заавар.УГЗЗГ. 1984 он.</li> <li>- Улсын геодезийн сүлжээний цэгийн төв, реперийн альбом. УГЗЗГ. 1984 он</li> <li>- Ажлын тайланг Агial, 12 фонтоор, мөр хоорондын зайг 1.15-аар бичнэ.</li> </ul>
7.	Ажил хугацаа	<p>гүйцэтгэх</p> <p>Эхлэх: Гэрээ байгуулсан өдрөөс эхэлнэ. Дуусах: 2024.11.01-ний дотор</p>
8.	Ажлын шалгалт	<p>хяналт</p> <ul style="list-style-type: none"> <li>- Захиалагч ажлыг 5 үе шатанд хяналт тавих бөгөөд хээрийн ажлын хяналтыг хээрийн ажил гүйцэтгэх явцад хийнэ.</li> <li>- Гүйцэтгэгч гэрээнд тусгасан хугацаанд 5 үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ</li> <li>- Захиалагч ажил шалгасан акт гаргаж, хяналтын ажлыг баталгаажуулна.</li> </ul>
9.	Архив, мэдээллийн төвд хүлээлгэн өгөх материал	<ul style="list-style-type: none"> <li>- Шинээр суулгасан цэг тэмдэгтийн хувийн хэрэг</li> <li>- Ажлын явцын тайлан</li> </ul>
10.	Захиалагч байгууллага	Чингэлтэй Дүүргийн Газар Зохион Байгуулалтын Алба
11.	Гүйцэтгэгч байгууллага	Геодезийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээд гүйцэтгэнэ.
12.	Санхүүжилт, эх үүсвэр	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар.
13.	Даалгаварт тусгагдаагүй ажил	Даалгаварт тусгагдаагүй ажлыг гэрээний нэмэлт нөхцлөөр гүйцэтгэнэ.


**ХЯНАСАН:**

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга



М.Туяа

Санхүү, Төрийн сангийн хэлтсийн дарга



Ц.Цэрэннамжил

**БОЛОВСРУУЛСАН:**

Газар зохион байгуулалтын албаны дарга



Х.Хишигбадрах